

ӨМНӨХ ҮГ

<https://doi.org/10.5564/mjb.v7i33.5375>

Шинжлэх ухааны Академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Монголын ботаникийн сэтгүүл”-ийн ээлжит 07 (33) дугаар хэвлэгдэн уншигч та бүхний гар дээр очиж байна. Тус дугаарт уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтол, бэлчээрийн даац хэтрэлт, хотжилт, хүний үйл ажиллагааны нөлөөлөл зэрэг байгаль орчны тулгамдсан асуудлуудыг ургамлын аймаг, экосистемийн түвшинд судалсан эрдэм шинжилгээний өгүүллүүдийг нэгтгэн толилуулж байна.

Энэ удаагийн дугаарт эмийн ашигт ургамлын тархалтын ирээдүйн чиг хандлагыг уур амьсгалын өөрчлөлттэй уялдуулан загварчилсан судалгаа, хээрийн ялгаатай бүсүүдийн ургамал бүлгэмдэл, хөрсний шинж чанар болон уур амьсгал, бэлчээрлэлтийн харилцан хамаарлыг тодорхойлсон үр дүнгүүдийг тусгав. Түүнчлэн ургамал нөмрөгийн доройтлыг таниур зүйл ургамлаар үнэлсэн, урт хугацааны ажиглалтад тулгуурлан хуурай хээрийн экосистемийн бүтэц, тогтвортой байдлын өөрчлөлтийг илрүүлсэн судалгаанууд багтлаа.

Мөн доройтсон бэлчээрийг хамгаалалтын ойн зурвас байгуулах замаар нөхөн сэргээх боломж, үр нөлөөг туршилтаар баталгаажуулсан, ургамлын тарималжилт, физиологи, экофизиологийн онцлогийг тодорхойлсон судалгаануудыг нийтэлсэн болно. Үүнд зарим эмийн болон нэн ховор ургамлын фотосинтез, усны солилцоо, дасан зохицлын онцлог, мөн модлог ургамлын агаарын бохирдолд тэсвэрлэх чадварыг үнэлсэн үр дүнгүүд орж байна.

Түүнчлэн ойн экосистемийн өөрчлөлт, сэргэн ургалт, мод огтлолтын дараах ургамал бүрхэвчийн хөдлөлзүй, ой үүсгэгч зүйлүүдийн үр, тоосны морфологи, чанарын ялгааг судалсан бүтээлүүдийг багтаалаа. Эдгээр судалгаанууд нь Монгол орны ургамлын аймаг, экосистемийн өөрчлөлтийн зүй тогтол, хамгаалал, зохистой ашиглалтын шинжлэх ухааны үндэслэлийг баяжуулахад чухал ач холбогдолтой юм.

Ийнхүү энэхүү дугаарт нийтлэгдсэн өгүүллүүд нь уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны нөлөөлөл дор ургамлын аймаг, ургамал бүлгэмдэл хэрхэн өөрчлөгдөж буйг олон талаас нь судлан харуулж, цаашдын хамгаалал, нөхөн сэргээлт, тогтвортой менежментийн шийдвэр гаргалтад шинжлэх ухааны үндэслэл бүхий чухал мэдээллийг бүрдүүлж байна.

Сэтгүүлийн ерөнхий редактор, Шинжлэх ухааны доктор,
профессор И.Түвшинтогтох

Эрхэм уншигч та бүхэн сэтгүүлийн талаарх болон хэвлэгдсэн өгүүллүүдэд өгөх санал, шүүмжээ доорх хаягаар ирүүлнэ үү.

И-мэйл: botany@mas.ac.mn mas.botany@gmail.com

Шуудангийн хаяг: 13330 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо, Энхтайваны өргөн чөлөө 54а, ШУА-ийн 1 дүгээр байр, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн, 413 тоот